

ЭРДЭНЭ РЕСУРС НЬ ХӨНДИЙ АЛТНЫ ДҮҮРГИЙН ТЕХНИКИЙН БОЛОН 2020 ОНЫ ХАЙГУУЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ТАНИЛЦУУЛЛАА

Хэвлэлийн мэдээ

Халифакс хот, Нова Скошиа муж
2020.06.10

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь өөрийн 100% эзэмшлийн Баян Хөндий Алтны Төслийн тусгай зөвшөөрлийн талбайд эхлүүлсэн 2-р улирлын хээрийн ажил болон техникийн судалгааны тухай мэдээлэл хүргэж байна.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Бид Баян Хөндий төслийн эцсийн ТЭЗҮ-ийг эцэслэх шат руу орж байгаатай зэрэгцэн бүтээн байгуулалт, олборлолтын үйл ажиллагаанд бэлтгэхээс гадна хайгуулын хэтийн төлөв бүхий бүсүүдийг нарийвчлан судлах ажлуудыг гүйцэтгэж байна.” “Бид 6-р сард хээрийн ажлыг эхлүүлсэн бөгөөд үүнд: эрдсийн хаягдлын байгууламж болон ус хангамжийн системийн инженерийн нарийвчилсан судалгаа, Баян Хөндий орд орчмын өрөмдлөг, Хар Морь (“Dark Horse”) талбайн гадаргын хайгуулын хөтөлбөр багтаж байна. Эдгээр хөтөлбөрийн үр дүнгүүд нь эцсийн ТЭЗҮ-ээс төслийн санхүүжилт болон бүтээн байгуулалтын ажлууд руу шилжихэд дэмжлэг үзүүлэхээс гадна ирээдүйн өндөр хэтийн төлөв бүхий талбайнуудыг үргэлжлүүлэн тодорхойлох ач холбогдолтой.”

Тэрээр үргэлжлүүлэн: “Өнгөрсөн хагас жилийн хайгуулын үр дүнгүүд нь Хөндий алтны дүүргийн өсөлтийн боломжийг баталгаажуулсан. Баян Хөндий ил уурхайн нөөцийг өмнө зүгт тэлэх боломж, шинээр өндөр агуулга бүхий газрын дөт гүнд Хар Морь талбайг нээн илрүүлж, Алтан Нар ордын Нээлтийн Бүсэд орших өндөр агуулга бүхий талбайг тэлж, шинэ алтны дүүргийн боломжууд нээлттэй хэвээр гэдгийг харууллаа” хэмээн танилцууллаа.

Уурхайн бүтээн байгуулалтын бэлэн байдал

Эрдэнэ Ресурс нь эцсийн ТЭЗҮ боловсруулахтай зэрэгцэн Баян Хөндий Алтны Төслийн (“Төсөл”) уурхайн бүтээн байгуулалтын бэлэн байдлын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөрүүд нь төслийн алт олборлолтыг үе шаттайгаар зардал хэмнэн хурдасгах зорилготой юм. Бүтээн байгуулалтын бэлэн байдлыг хангах хөтөлбөрт:

- Төслийн тусгайлсан хяналт, системийг боловсруулах
- Төслийн баг бүрдүүлэх
- Оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх, тусгай зөвшөөрлүүдийг авах
- Боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийг бэлтгэх
- Худалдан авалт болон тендерийн үйл явцыг ахиулах
- Төслийн талбайд тоног төхөөрөмж, хангамж, хүмүүсийг аюулгүй хүргэх ложистик, дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах зэрэг багтаж байна.

Эцсийн ТЭЗҮ-ийн хүрээнд бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд чиглэсэн Монгол болон олон улсын туршлагатай мэргэжилтнүүдийг урьж ажиллуулахаар урьдчилсан төслийн багийн бүтцийг тодорхойлсон. Эцсийн ТЭЗҮ-ийг эцэслэхэд төслийн баг нь анхан шатны барилга байгууламж, байнгын суурин кемп барихад шаардлагатай тусгай зөвшөөрөл, оролцогч талуудтай харилцах, худалдан авалт, талбайн бэлтгэл зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Дээр дурдсан хүчин чармайлтууд нь 2021 оны эхэнд бүтээн байгуулалтын ажлыг хурдацтай хийж гүйцэтгэхэд чиглэсэн.

Одоогийн хийгдэж буй хээрийн ажлуудад талбайн техникийн хөтөлбөрүүд болох нөөцийн зэрэглэл ахиулах өрөмдлөг, инженерчлэлийн нарийвчилсан мэдээлэл цуглуулах, эрдсийн хаягдлын байгууламжийн тусгай зөвшөөрөл, ус хангамжийн системийн тусгай зөвшөөрөлд шаардлагатай геотехникийн ажлууд болон барилгын материалыг тодорхойлох судалгааны ажлууд багтаж байна.

Баян Хөндий алтны ордын нөөцийн зэрэглэл ахиулах өрөмдлөг:

Баян Хөндий ордын орчим газрын дөт гүнд 1,000 метрийн 25 цооног өрөмдөх хөтөлбөрийг энэ долоо хоногт эхлүүлсэн. Энэхүү хөтөлбөрөөр хаягдал эсвэл бага агуулгатай овоолгын материал хэмээн ангилагдсан бүсүүдэд эрдэсжилт байгаа эсэхийг шалгах ба нарийвчилсан судалгаа хийснээр олборлолтын эхний үе шатанд үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжтой.

2019 онд урьдчилсан ТЭЗҮ-ийн нөөцийг тодорхойлох өрөмдлөгийн хүрээнд зүүн Мидфийлд талбайд газрын дөт гүнд өндөр агуулга бүхий бүсийг огтолж, үргэлжилж байгааг тодорхойлсон боловч баталгаажуулахад өрөмдлөгийн торын нягтрал хангалтгүй байсан. Страйкер бүсээс өмнө зүгт гадаргын чулуулгийн дээжлэлтээр илрүүлсэн өндөр агуулга бүхий дээж, суваг ухах үед илрүүлсэн нүдэнд харагдахуйц алт бүхий дээж зэрэг нь өрөмдлөг ба нөөцийн блок-д багтаагүй. Газрын дөт гүнд хийх нягтруулсан торлолтой өрөмдлөг нь эдгээр бүсүүд хүдрийн бүсийнөргөтгөл болох боломжтой эсэх болон олборлолт эхлэхээс өмнө ирээдүйн уурхайн төлөвлөлтөд нөлөөлөх хүчин зүйл болох эсэхийг тодорхойлох боломжтой.

Хайгуулын хөтөлбөрийн онцлог болон төлөвлөгөө (Хавсаргасан зурагтай танилцана уу)

Хөндий алтны дүүрэгт Баян Хөндий ил уурхайн хөгжүүлэлтээс гадна хайгуул хөгжүүлэлтийн олон боломжууд байгаа ба эдгээрт 2019 оны өрөмдлөгийн хөтөлбөрөөр илрүүлсэн Баян Хөндийн тэлэлтийн бүсүүд, шинээр нээн илрүүлсэн Хар Морь талбай, 2020 оны эхээр танилцуулсан Алтан Нар төслийн маш өндөр агуулга бүхий буцлалтын бүс (Boiling zone) зэрэг багтаж байна. Гол талбайнуудын тухай товч мэдээлэл болон төлөвлөж буй хөтөлбөрүүдийн талаар мэдээллийг доор хүргэв.

Баян Хөндий – Төлөвлөсөн уурхайн хананаас гадна тэлэлт болон хайгуулын ажил

Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодит геологийн нөөц¹ (“Measured and Indicated Resources”), түүнд 3.7 г/т алтны агуулга бүхий 420,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтаж байна. Түүнээс гадна 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц (хэвлэлийн мэдээтэй [энд](#) дарж танилцана уу)

¹ Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2019 оны 12 сарын 4-нд SEDAR-т байршуулсан Тетра Текийн боловсруулсан NI 43-101 техникийн тайлангаас танилцана уу.

тодорхойлогдсон. Эдгээр нь уурхайн тэлэлт болон гүний уурхайн олборлолтоор үлдсэн баттай ба бодит болон боломжтой нөөцийг олборлох боломжийг нэмэгдүүлж байна.

Баян Хөндийн төлөвлөсөн ил уурхайгаас гадна хэд хэдэн эрдэсжсэн бүс болон хайгуулын талбайд тодорхойлсон нь маш өндөр алтны агуулга бүхий хэд хэдэн судлууд (1 метрийн турш 30-150 г/т алтны агуулга бүхий интервал) огтолсон. Эдгээр талбайд хийгдсэн хайгуулын торны нягтрал харьцангуй өргөн бөгөөд өндөр агуулга бүхий талбайнууд нь Баян Хөндий нөөцийн бүсийн гадна оршиж байна. Зарим талбайд илүү нарийвчилсан өрөмдлөгийг хийснээр цар хүрээ, агуулгыг тодорхойлж болох бол зарим талбайд хиймэл дагуулын зураглалаар шинэ ордын нээлт хийх, одоогийн нөөцийн хязгаарыг тэлэх Баян Хөндий эпитеpmаль системийн хэтийн төлөвийг тодорхойлох боломжтой. Баян Хөндийн голлох талбайн мэдээллийг дор танилцуулав.

Баруун Стайкер ба өмнө зүгт тэлэлт: Баян Хөндий төлөвлөсөн уурхайн хананаас баруун зүгт 210 метрт оршдог энэхүү талбайд 2019 оны 2-р улиралд өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, өнөөг хүртэл талбайд тодорхойлсон хамгийн өндөр агуулга буюу 136 метрийн босоо гүнд 40 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал огтолсон (BKD-265²). BKD-265 цооногоор мөн дөт гүнд эрдэсжсэн бүс үргэлжилж байгааг тодорхойлсон, үүнд: 28 метр гүнд 2.7 г/т алтны агуулга бүхий 5 метрийн интервал агуулсан 1.1 г/т алтны агуулга бүхий 16 метрийн интервал илрүүлсэн. 2019 оны 2-р улиралд төлөвлөсөн уурхайн хананаас баруун хойд зүгт 250 метрт одоогийн нөөцийн хязгаараас гадна BKD-266 цооногийг өрөмдсөн. Энэхүү цооногоор 264 метрийн гүнд 51.9 г/т өндөр алтны агуулга бүхий 1 метрийн интервал огтолж цахиур-иллит ба магнетитийн хувиралд орсон галт уулын чулуулгийн өргөн бүсийг огтолсон нь Баян Хөндийн уурхайн одоогийн тодорхойлсон өндөр агуулга бүхий эрдэсжилтийн үргэлжлэл болон доош сунасан байх боломжтойг харуулж байна. 2019 оны 3-р улиралд Баян Хөндий ордоос өмнө зүгт нөөцийн тэлэлт хийх зорилгоор өрөмдсөн цооног (BKD-268²)-ийн үр дүнд Баян Хөндий ордтой адил 100 метр нягт үелэн хувирсан галт уулын туфыг огтолсон бөгөөд 100 метрийн гүнд алт агуулсан туф нь 2.45 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал огтолсон. 2019 оны өрөмдлөгийн хөтөлбөрөөр ордын өмнө зүгт нөөцийг тэлэх боломж, баруун зүгт тэлэх боломжтой шинэ бүсүүд байгааг тодорхойллоо.

Зүүн Баян Хөндий: Төлөвлөсөн ил уурхайн зүүн зүгт төлөвлөсөн налуу замын дор орших талбайд ойролцоогоор 150 метрийн босоо гүнд BKD-118² цооногийг өрөмдсөн нь 55 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал огтолсон. Энэхүү зүүн бүсэд хязгаарлагдмал өрөмдлөг хийгдсэн бөгөөд төлөвлөсөн ил уурхайн хязгаар болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн хил хязгаарын хооронд судлагдаагүй өргөн талбай байна.

Хойд Баян Хөндий: Төлөвлөсөн ил уурхайн трендийн дагуу хойд ба зүүн хойд зүгт 400 метрт цахиур-иллит ба магнетитийн хувиралд орсон галт уулын чулуулгийн өргөн (150 метрийн турш) бүсэд аномаль алт (1 г/т-оос өндөр агуулга бүхий) илрүүлсэн. Уурхайн хязгаарын хойд зүгт орших энэхүү бүсэд сийрэг торлолтой өрөмдлөгүүдээс бусдаар хязгаарлагдмал судалгаа хийгдсэн.

Дараагийн шатны өрөмдлөгийн хөтөлбөрт зориулан Баян Хөндийн геологи, геофизик болон структурийн загварчлал үргэлжлэн хийгдэнэ.

² Дурдсан интервалууд нь жинхэнэ зузаан биш болно. Одоогийн хүдрийн хэлбэр болон жинхэнэ зузааныг тодорхойлох хангалттай өгөгдлийн сан байхгүй байна.

Хар Морь (Dark Horse) –Өрөмдлөгийн судалгаа хийгдээгүй байгаа алтны өндөр агуулга бүхий судлын систем

Хар Морь талбай нь Баян Хөндий ордоос зүүн хойш 3.5 км-т Эрдэнэ Ресурсийн 100% эзэмшдэг Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд оршдог. Энэхүү талбайг 2019 оны 4-р улиралд кварцын судал, штокверк агуулсан том хэмжээний турмалины бүсэд 32.9 г/т алтны агуулга бүхий чулуулгийн дээж авснаар илрүүлсэн. 2019 оны 4-р улиралд нэмэлт гадаргуун дээжлэлт хийсэн бөгөөд чулуун дээжид комб кварц-адуларын судалд 87.8 г/т алтны агуулга багтаасан 5 г/т-аас дээш алтны агуулга бүхий интервал илэрсэн. 2019 оны 4-р улиралд гүйцэтгэсэн хайгуулын ажил нь Хар Морь талбайг баруун зүгт 1.5км x 2км болгон тэлснээр зэргэлдээ орших Алтан сум алтны хэтийн төлөв бүхий талбайтай залгаа болов. Алтан сум талбайн өмнө зүгт туслах структурын (Хар Морь талбайгаас 300 метрт орших) дагуу хийсэн өрөмдлөгөөр өнөөг хүртэл хамгийн өндөр үр дүн буюу газрын гадаргаас 75 метрийн гүнд 24 г/т-70 г/т алтны агуулга бүхий 2 метрийн интервал огтолсон.

2020 оны 1-р улиралд Wave Geophysics компани нь Хар Морь талбайн геофизикийн мэдээллийн санг нэгтгэн, хараат бус тайллыг хийж гүйцэтгэсэн. Энэхүү нарийвчилсан үнэлгээ нь геологи, структурийн хувьд энэхүү талбайг илүү ойлгох, магнетитийн задрал бүхий хувирсан бүс нь Баян Хөндий ордтой ижил төстэй эсэхийг тодорхойлоход дэмжлэг үзүүлсэн. Геофизикийн судалгаанаас гадна хөрсний болон чулуулгийн дээжийн геохимийн нарийвчилсан судалгаа, зураглал, суваг ухах зэрэг хөтөлбөрүүдийг гүйцэтгэж байна. Энэ нь Хар Морь талбайд ирээдүйн өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс өмнө талбайн эрдэсжилтийн чиглэл, давтамжийг тодорхойлох ач холбогдолтой.

Хэдийгээр хайгуулын анхан шатанд явж байгаа боловч Баян Хөндий ордын хөгжүүлэлттэй харьцангуй ойр оршдог, ордтой ижил төстэй байдал, гадаргын дээжлэлтээр маш өндөр алтны агуулга (87 г/т алт) илрүүлсэн зэрэг нь энэхүү нээлтийг тун сонирхолтой болгож байна.

Алтан Нар – 1-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнгээр Алтан Нар төслийн талбайд өндөр агуулга үргэлжилж буйг батлан, шинэ боломжуудыг тодорхойлов

Баян Хөндий ордоос 16 км-т орших Алтан Нар төслийн өсөн нэмэгдэж буй алт, полиметаллын нөөц нь өнөөгийн өндөр агуулга бүхий нөөцийг өсгөх томоохон боломжийг олгож байна. 2019 оны 4-р улиралд хайгуулын баг нь өөрийн 100% эзэмшлийн Алтан Нар төслийн 5.6 км эрдэсжсэн трендийн дагуу 18 хэтийн төлөв бүхий талбайн нэг Нээлтийн Бүс (“Discovery Zone”)–д эпипермаль буцлалтын бүс (epithermal boiling zone) байж болох өндөр агуулга бүхий алтны эрдэсжилттэй давхаргыг амжилттай шалгасан. Үр дүнд 17 г/т алт, 44.7 г/т мөнгө, 0.75% хар тугалга, 1.47% цайрын агуулгатай 17 метр интервал бүхий хар, сульфидоор баяжсан эпипермаль брекчийг (TND-135) огтолсон нь урьд нь Нээлтийн Бүсийн өндөр агуулга бүхий судлагдаагүй бүсэд хийсэн өрөмдлөг юм. TND-134 цооногийн үр дүн нь Нээлтийн Бүсийг суналын дагуу 20 метрээр тэлэн, өндөр агуулга бүхий цөм тасралтгүй үргэлжилж буйг баталгаажууллаа. Ингэснээр Алтан Нар ордын нөөцөд эерэг үр дүн авчрах боломж үүсэж байна. Түүнээс гадна нэмэлт өрөмдлөгүүдээр (TND-134, TND-137) Алтан Нарын трендийн дагуу хэд хэдэн талбайд өндөр агуулга байгаа эсэхийг үргэлжлүүлэн судлах зорилгоор өрөмдсөн. Тусгай зөвшөөрлийн талбайд хайгуул судалгаа хязгаарлагдмал хийгдсэн бөгөөд нөөцийн 90% нь газрын дөт гүнд буюу 150 метрт агуулагдаж байна. Нөөц нь хэтийн төлөв бүхий 18 талбайн хоёрт агуулагдаж, суналын дагуу болон гүндээ нээлттэй байна. 2019 оны 4-р улирлын үр дүнгээр Нээлтийн Бүсийн цөмийн өндөр агуулга болон хэмжээг үргэлжлүүлэн, ирээдүйд тэлэх боломжтойг тодорхойлсон. Wave Geophysics компани нь Алтан Нар төслийн мэдээллийн санг нэгтгэж, анхан шатны тайлал болон

зөвлөмжийн үе шатыг дуусгасан бөгөөд дараагийн өрөмдлөгийн хөтөлбөрөөс өмнө тайллыг хийхээр төлөвлөж байна.

Эдгээр гурван тэргүүлэх зорилтот талбай нь хайгуулын маш өндөр хэтийн төлөв бүхий бүсэд оршдог, хайгуул хязгаарлагдмал хийгдсэн талбайнууд бөгөөд энэхүү бүсэд урд нь ажиллаж байсан мэдлэг, туршлагатай баг хайгуул хийж байгаагаараа онцлогтой. 2020 оны 3-р улиралд хайгуулын хөтөлбөрийн үр дүн болон одоогоор гүйцэтгэж байгаа судалгаануудыг эцэслэж, ирээдүйн өрөмдлөгийн хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулна.

КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэхээр хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд:

Компани нь КОВИД-19 вирусний тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Хээрийн ажлын хүрээнд гараа тогтмол угаах, байнгын ариутгал цэвэрлэгээ хийх зэргээр агааржуулалт, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлэн, ажилтнуудаа халдвараас сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Өдөр тутам сэрэмжлүүлэг, зөвлөмжийг өгч, танилцуулга хийн, зочин хүлээн авах журмыг шинэчилж, биеийн температур шалгах ажлыг тогтмолжууллаа. Шаардлагатай нөхцөлд ашиглах зорилгоор тусгаарлах байр, хувийн хамгаалалтын хэрэгслүүдийг бэлтгэсэн. Нэгдүгээр сараас эхлэн Монгол Улсын засгийн газар олон улсад зорчих иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах, бүх шатны хичээл сургалтын үйл ажиллагааг хязгаарлах, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох зэргээр иргэдээ вирусээс хамгаалах арга хэмжээнүүдийг үр дүнтэйгээр хэрэгжүүлж байна. 6-р сарын 8-ны байдлаар Монгол Улсад дотооддоо вирусний тархалт илрээгүй бөгөөд олон улсын зорчих хөдөлгөөнөөс үүдсэн халдварын тоо 194 хүрч, тусгаарлагдан эмчлүүлж байна.

Хөндий Алтны Төслийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

2019 оны 10 сард Эрдэнэ Ресурс нь Хөндий Алтны Төслийн техникийн тайланг (Хэвлэлийн мэдээтэй [эндээс](#) танилцана уу) танилцуулсан бөгөөд энэхүү техникийн тайланд Баян Хөндий ордын (“Bayan Khundii”) урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл (“урьдчилсан ТЭЗҮ”, “PFS”) болон Алтан Нар ордын (“Altan Nar”) шинэчилсэн анхан шатны эдийн засгийн тооцоолол (“АШЭЗТ”) орсон болно. Урьдчилсан ТЭЗҮ-д Баян Хөндий, Алтан Нар ордын татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (“NPV5%”) (алтны үнийг \$1,300 ам.доллар/унц байхаар төсөөлөхөд) тус бүр \$97 сая ам.доллар, \$24 сая ам.доллараар тооцоологдсон. Баян Хөндий ба Алтан Нарын дотоод өгөөжийн түвшин (“IRR”) нь тус бүр 42%, 90% гэж тооцоолсон. Урьдчилсан ТЭЗҮд 0-7 жилд Баян Хөндий ордыг ашиглах ба 3.73 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд дунджаар 61,000 унц алтыг илээр олборлох, 7-10 жилүүдэд Алтан Нар ордыг ашиглан, 3.46 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд дунджаар 48,000 унц алтыг олборлохоор төлөвлөж байна. Баян Хөндий ордод уламжлалт нүүрсэнд уусгах технологийн боловсруулах үйлдвэрийг байгуулахаар төлөвлөсөн. 2019 оны 8-р сард Баян Хөндий ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд компани нь төслийг олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлж байна.

Анхан шатны эдийн засгийн тооцоолол нь урьдчилсан таамаглал бөгөөд зарим тооцоололд боломжит нөөц агуулсан. Боломжит нөөц нь урьдчилсан болон эцсийн техник, эдийн засгийн тооцоололд нөөц хэмээн багтаахад геологи, эдийн засгийн хувьд эрсдэл ихтэй. Эдийн засгийн үр ашиг багатай геологийн нөөцийг үйлдвэрийн нөөц, эдийн засгийн тооцоололд багтаахгүй.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 3 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com-оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээллийг авахыг зөвлөж байна.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд COVID-19 вирусний тархалтаас үүсэх компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болох нөлөөлөл, гуравдагч талын зөвшөөрлийг авах, эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>

KHUNDII GOLD DISTRICT

Three deposits, multiple prospects, limited exploration

Fast tracking to production

Altan Nar Deposit (Au, Ag, Zn, Pb)

Nomin Tal

Road to Shinejinst

Proposed Haulroad

Oyut Khundii

Altan Arrow

Khar Mori

Khundii North

Ulaan

Bayan Khundii Deposit (Au)

Khuvyn Khar

Zuun Mod Deposit (Cu, Mo)

0 5 10


kilometers



BAYAN KHUNDII

Multiple Prospects On License

Fast tracking to production



BAYAN KHUNDII

Areas for Expansion Adjacent to Open Pit

Fast tracking to production

